

# Living the Lotus

5

2024

VOL. 224

*Buddhism in Everyday Life*



Risho Kosei-kai  
of Seattle



## Living the Lotus Vol.224 (2024.05)

Ахлах редактор: Акагава Кэйичи  
Орчуулсан: Б.Мөнхцэцэг, Т.Оюу-Эрдэнэ  
Эхийг хянасан: Ш.Зоригмаа  
Хэвлэсэн: Рисшо Косей Кай, Олон улсын хэлтэс  
Хаяг: Fumon Media Center, 2-7-1 Wada,  
Suginami-ku, Tokyo 166-8537 Japan  
TEL: +81-3-5341-1124  
FAX: +81-3-5341-1224  
Email: living.the.lotus.rk-international@  
kosei-kai.or.jp

Рисшо Косей Кай байгууллага нь Үүсгэн байгуулагч Нивано Никкёо, хамтран үндэслэгч Наганүма Мёокоо нарын санаачлагаар 1938 онд байгуулагдсан ба “Лянхуан Гурамсан Судар”-ыг гол сургаал номлолоо болгодог, лам бус эгэл хүмүүс нэгдсэн буддын шашны байгууллага юм. Өөрөөр хэлбэл Шагжамүни бурхан багшийн сургаалыг гэр бүл, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлж, дэлхийн энх тайвныг бүтээн байгуулья гэсэн хүсэл зорилготой хүмүүсийн нэгдэл юм. Бид тус байгууллагын ерөнхийлөгч Нивано Ничикоогийн удирдлага дор бурханы сургаалыг түгээх үйлсэд зүтгэж, шашны төдийгүй бусад салбарын байгууллагууд, дэлхийн олон орны хүмүүстэй сэтгэл нэгдэн энх тайвны үйлсэд хувь нэмэр оруулж байна.

*Living the Lotus – Buddhism in Everyday Life (Амьд Цагаан Лянхуа судар – Буддизм бидний амьдралд)” хэмээх тус сэтгүүлийн нэрэнд Цагаан лянхуа судрын сургаалыг өдөр тутмынхаа амьдралд хэрэгжүүлж, шаварт ургадаг үзэсгэлэнт лянхуа цэцэг мэт үр бүтээмжтэй, үнэ цэнтэй амьдралыг туулцаага гэсэн хүсэл шингэсэн билээ. Энэхүү сэтгүүлээр дамжуулан өдөр тутамдаа хэрэгжүүлж болох бурханы сургаалыг дэлхийн өнцөг булан бүрт хүргэж байна.*





## Дөлгөөн зантай хүний сэтгэл нь эрх чөлөөтэй

Рисшо Косей Кай, ерөнхийлөгч  
Нивано Ничикоо

### Үхрийн буулгыг тайлах нь <sup>1</sup>

Жил бүрийн энэ улирал болмогц нягтарсан хөрсийг сийрүүлэх, бордох гэх мэтээр тутарга үрслүүлэх бэлтгэлд тусалдаг байсан багын дурсамж сэргэдэг. Энэ бол миний 5, 6-р анги билүү 7, 8-р анги орчимд тутаргын талбайг хагалах үхрийн дөрнөөс<sup>2</sup> татаж байсан үеийн дурсамж юм даа. Сүрлэг биетэй үхрийн дөрнөөс татахад “фүү” гээд тургих ширүүн дуунаас нь айдаг байсан боловч тэр үхэр ч бидний хувьд нэгэн дээвэр дор амьдардаг чухал гэр бүлийн гишүүн байсан. Нийгата мужийн Сүганүма тосгон дахь Үүсгэн байгуулагчийн төрсөн гэрт анх очоод, хаалгыг нь онгойлгон бүүдгэр гэрэлтэй үүдээр алхан ороход морьны зүчээнээс үнэртсэн тэр содон үнэр одоо хэрнэ ой санаанд тод үлджээ.

Ийнхүү үхэр, морьтойгоо нэг дээвэр дор хамт амьдарч үзсэн миний хувьд Шагжамүни бурханы үгийг нэгтгэсэн “Сүтта нипата” сударт гардаг “Аядуу дөлгөөн зан нь үхрийн буулгыг тайлахтай ижил.” гэсэн нэг мөрт гүн сэтгэгдэл төрүүлсэн. Энэ мөрт үхэр, морьтойгоо харьцах эзний харилцаа, тэндээс урган гарах энэрэнгүй сэтгэлтэй гүнзгий холбоотой мэт санагдана. Өдөржин газар хагалсан үхэрт зүүсэн буулгыг тайлах үе нь “өнөөдөр ч гэсэн сайн ажиллаа, баярлалаа” гэсэн талархсан сэтгэлийн илэрхийлэл байдаг. Үүнийг “аядуу зөөлөн, номхон байдал”-ыг илэрхийлэх “дөлгөөн” гэх ганц үгэнд багтаасан ба гэр бүлийн нэг гишүүн болох үхэртээ гаргаж буй тариачны энэрэнгүй сэтгэл лүгээ бүх хүн “амар амгалан байх болтугай” хэмээн хүссэн Шагжамүни бурханы сэтгэл ч гэсэн энэхүү ганц мөртөд шингэсэн гэж бодож байна.



## Хүлээснээс ангижрахуй

“Буулгыг тайлах” гэдгийг өөр өнцгөөс харах юм бол хүмүүс бид өөрийгөө хүлээд байгаа хүлээсээ тайлаад амьдрах ямар чухал вэ гэдгийг онцгойлон сургасан.

Үзэл бодол, аливаа зүйлд автах сэтгэл ихтэй хүн төрөлхтөн бид ургамал, амьтан шиг юунд ч хүлэгддэггүй эрх чөлөөтэй амьдрах боломжгүй. Тэрхүү хүлээснээс үүдэж зовлон зүдгүүр үүсдэг боловч бурхан, бодьсдва шиг юунд ч үл автах самадигийн түвшинд хүрдэггүй юмаа гэхэд сэтгэлийн хүлээснээсээ өчүүхэн ч болтугай салж, уур бухимдал багатай, эрч хүчтэй амар амгалан өдрүүдийг өнгөрүүлэхийг хэн хүнгүй хүсэх буй за.

Эдогийн үеийн Зэн мастер Шидоо Бүнан (1603-1676) “Юу ч бодохгүй байх нь бурханы түвшин”, “юу ч бодохгүй байгаа юм шиг юм болгоныг хийх хэрэгтэй” гэж хэлсэн байдаг. Зэн мастер өөрөө ч аливаа зүйлийг хийхдээ ямар нэг зүйлд хүлэгдэхгүй байхыг хичээдэг байсан гэгддэг. Мөн ийм нэг яриа бий:

Шидоо Бүнан мастерийг ихэд хүндэлдэг нэгэн чинээлэг настан байсан ба түүнийг тосгондоо ирэхэд нь хонож байх сууц хүртэл бэлдэж өгсөн ажээ. Нэг өдөр настан охиноо жирэмсэн гэдгийг мэдэв. Хэнээс жирэмсэн болсныг асуутал охин нь “Зэн мастераас...” гэж худал хэлжээ. Настан ихэд уурсаж, тэр дороо мастер дээр очоод хамаг муу үгээр харааж зүхээд тосгоноосоо хөөн гаргаж гэнэ. Гэтэл удалгүй охин нь “хараалгаж загнуулахаас айгаад хүн болгоны хүндэлдэг Зэн мастерийн хүүхэд гээд хэлчихвэл гайгүй өнгөрөх байх гэж бодоод...” хэмээн худал хэлснээ хүлээдэг.

Настан сандран Зэн мастер дээр очоод, нулимс дуслуулан уучлалт гуйжээ. Тэгэхэд Зэн мастер “хөгжилтэй нь аргагүй инээгээд энэ талаар хоромхон ч бодоогүй тул хэнийг ч бүү буруутга” гэж хэлсэн нь эртний номонд тэмдэглэгдэн үлдсэн байдаг. Ямар ч хүнтэй эелдэг зөөлөн харьцдаг энэрэл нигүүлсэл дүүрэн, аядуу дөлгөөн зантай, автах сэтгэлгүй хүний нэг бол яах аргагүй энэхүү Шидоо Бүнан мастер билээ.

Дашрамд дурдахад “Шидоо Бүнан” гэдэг нь Зэн урсгалын богино шүлгийн нэг бөгөөд “үнэнд хүргэх зам мөр огтхон ч хэцүү биш” гэсэн утгатай. Аливаа зүйлд хандахдаа дуртай дургүй гэж ангилалгүй, өөрийнхөө санаснаар байлгах гэж зүтгэхгүй байх нь бурханы зам мөр гэсэн үг.

Үүсгэн байгуулагч дөлгөөн зангийн тухайд “Эхлээд сэтгэлээсээ биш ч байсан хамаагүй инээгээд л байх хэрэгтэй. Дөлгөөн байдлыг хичээх аваас аяндаа оюун санаанд тань уусан шингэх болно” хэмээн айлдсан байдаг. Гиймээс бурхан шиг дөлгөөн хийгээд эрх чөлөөтэй хүн болохсон хэмээн залбирч, аливаа зүйлийг аль болох инээмсэглэн хүлээж авцгаая.



1. *буулга*: малыг тэргэнд хөллөхдөө хүзүүн дээгүүр нь хавчин тавих бөгтөр мод
2. *дөр*: үхрийн хамрыг нүхлэн хатгасан мод



# Рисшо Косей Кай байгууллага (Зурагт ном)

## Шинэхэн гишүүн танаа

### Гол шүтээн

Рисшо Косей Кай нийгэмлэгийн Гол шүтээн бол “Ялж төгс нөгчсөн дуусашгүй буян үйлдэгч номын хаан Шагжамүни” бурхан юм. Цагаан лянхуа сударт Ялж төгс нөгчсөн бурхан эрт үеэс энэ ертөнцөд оршсоор ирсэн ба хүн хүнд тохирсон аргаар олон хүнд сургаалаа айлдаж ирсэн гэж тэмдэглэсэн байдаг. Үүсгэн байгуулагч энэ ишлэлд үндэслэн Шагжамүни

бурхныг Гол шүтээнээ болгосон. Мөн энэхүү шүтээн зогсож буй босоо дүртэй байгаа нь бүх хүмүүсийг аварна гэсэн тэмүүллийг илэрхийлдэг.

Гол шүтээн дотор Үүсгэн байгуулагчийн хичээнгүйлэн хуулж бичсэн Цагаан лянхуа судар хадгалагддаг.



#### Чимх мэдлэг

Гол шүтээний арын гэрэлт цацраг дээр Олон эрдэнийн Татагата болон дөрвөн их бодисадваг байрлуулсан байдаг.

Эгц дээд талд Олон Эрдэнийн Татагата, өөдөөс нь хараад баруун дээд талд Дээд үйл, баруун доод талд Хязгааргүйн үйл, зүүн дээд талд Ариун үйл, зүүн доод талд Амарлингуйн үйл бодисадваг байрлана.

\* Хувьдаа ашиглахаас бусад тохиолдолд зөвшөөрөлгүй олшруулж, мэдээллийн хэрэгсэл дээр байршуулахыг хориглоно.





## Өглөө оройн судар уншлага



Нийгэмлэгийн гишүүд өглөө оройд 2 удаа судраа уншдаг. Орхимжоо зүүж, судар эрхий бариад гүнгэрвааныхаа өмнө суугаад өдөр бүр номоо ягштал уншихад сэтгэл санаа сэргэдэг. Судраа уншихын өмнө ус, цай, будааг бурхандаа өргөж, цэцгийн савныхаа усыг солиорой. Лаа, хүж асаахдаа галаас болгоомжлоорой.

Ийнхүү бэлтгэлээ базаагаад өглөө тухайн өдрийнхөө зорилгыг тунгааж, оройд талархлын сэтгэлээ шингээн судраа уншвал зохилтой.





## Амар амгалан явахуйн сургаалаас суралцах хүлээцтэй, зөөлөн сэтгэл

Акагава Кэйичи

Та бүгдийн амгаланг эрье.

5 сар гарч шинэхэн цэцэг ногооны улирал ирлээ. Японд 5 сарын эхээр урт амралт тохиож олон хүмүүсийн сэтгэл сэргэдэг үе ч гэлээ аялал жуулчлалын газар, хурдны замын ачаалал ихэссэнээс санаанд оромгүй эмх замбараагүй байдал үүсэх нь цөөнгүй.

Нивано ерөнхийлөгч энэ нөхцөл байдлыг таамагласан болов уу гэмээр энэ сарын айлдвартаа “Дөлгөөн зантай хүний сэтгэл нь эрх чөлөөтэй” гэсэн сэдвийн дор бид ямар хандлага, үйл хөдлөлийг санаж явбал зохилтойг сургажээ.

“Аядуу дөлгөөн хүн” гэдгийг сонсоод юун түрүүнд “Цагаан лянхуа судар”-ын “Амар амгалан явахуйг өгүүлэх 14-р бүлэг” дэх “Бодьсадва хүн хэзээд хүлээцтэй, аядуу зөөлөн, уурлаж уцаарладаггүй байвал зохилтой” гэсэн мөр санаанд буулаа. Судрын энэхүү 14-р бүлэг бол суралцахуйн гүн гүнзгий агуулгатай учраас Нивано ерөнхийлөгч магистрын дипломын ажлынхаа сэдвээр сонгосон байдаг.

Яг л өдөр тутмын амьдралаас урган гарсан, амьдралын практик ухаанаар дүүрэн бүлэг билээ. Энэ бүлгээс “Тэвчээртэй, эелдэг зөөлөн байгаарай.” гэсэн Бурхан багшийн намуухан дуу хоолой сонсогдох болов уу.

Энэ жилийн 5 сарын амралтаар 14-р бүлгийн дээрх мөрийг санан, сэтгэлийн эрх чөлөөг эдлэхийн төлөө бурханы үйлд хичээе гэж бодож байна.



Акагава хэлтсийн дарга (урд эгнээний голд ) 2024 оны 3 сарын 22, 23-ний өдөр Лос-Анжелас салбарт болсон Хойд Америкийн нийгэмлэгийн дарга, ТУЗ-ын гишүүдийн хуралд оролцсон нь




# Rissho Kosei-kai International

Make Every Encounter Matter



## 🌸 A Global Buddhist Movement 🌸



Information about local Dharma centers



✉ We welcome comments on our newsletter Living the Lotus: [living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp](mailto:living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp)